



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Тусгаар тогтнол, Эв нэгдлийн нам (ТТЭНН)-ын
шинэчилсэн дүрмийг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Э.Золзаяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Тусгаар тогтнол, Эв нэгдлийн нам (ТТЭНН)-ын шинэчилсэн дүрмийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч П.Соёл-Эрдэнийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Тусгаар тогтнол, Эв нэгдлийн намын дарга Ц.Баянбилэгээс “... 2026 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Тусгаар тогтнол, Эв нэгдлийн намын ээлжит бус 5 дугаар Их хурлыг зарлан хуралдуулж намын шинэчилсэн дүрэм, мөрийн хөтөлбөрийг тус тус баталсан байх тул бүртгэж өгнө үү” гэх өргөдлийг 47 хуудас баримтыг 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлжээ.

Дээрх өргөдөл, хавсралт баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 2.5-д заасны дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлсэн ба сонсох ажиллагааны явцад нэмэлтээр 295 хуудас баримт, 1 ширхэг мандат, 2 ширхэг флаш ирүүлснийг шалгаад, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-тай нийцүүлэх арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ” гэж заасан.

Тусгаар тогтнол, Эв нэгдлийн нам нь хуульд заасан хугацааны дотор өөрийн намын хөтөлбөр, дүрмийг шинэчлэн бүртгүүлэхээр 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Улсын дээд шүүхэд өргөдөл ирүүлсэн боловч тодорхой алдаа, зөрчилтэйн улмаас тухайн дүрмийг бүртгээгүй байна.

Харин Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар зөрчлөө зассаны үндсэн дээр дахин нэг удаа 60 хоногийн дотор намын дүрмээ бүртгүүлэх боломжийг олгосны дагуу тухайн нам нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д заасан шаардлагад нийцүүлэн дүрмээ баталсан байх тул Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Тусгаар тогтнол, Эв нэгдлийн намын шинэчилсэн дүрмийг дараах үндэслэлээр бүртгэж шийдвэрлэв.

Нэг.Намын удирдах дээд байгууллага болох Их хурлыг зарлан хуралдуулсан талаар:

Тусгаар тогтнол, Эв нэгдлийн намын дүрэм (2017 он)-ийн (цаашид “Дүрмийн” гэх) 17.3-т “Намын Их хурал хуралдах тов, төлөөлөгчдийн тоо, тэдгээрийг сонгох журмыг Бага хурал тогтооно”, 18.1-д “Намын Их хуралд сонгогдсон нийт төлөөлөгчдийн гуравны хоёроос илүү нь оролцож байгаа бол Их хурлыг хүчинтэйд тооцно”, 20.1-д “Намын Их хурлаас намын Бага хурлыг 50 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр дараагийн Их хурал хүртэлх хугацаагаар байгуулна ...”, 21.2-т “Намын Бага хурлын хуралдааныг ... Намын Удирдах Зөвлөлийн санаачилгаар, ... зарлан хуралдуулж болно”, 21.5-д “Нийт гишүүдийн олонх нь оролцож байгаа бол намын Бага хурлыг хүчинтэйд тооцно” гэж тус тус заажээ.

Өргөдөлд хавсаргасан баримтуудаас үзвэл, тус намын Удирдах зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн УЗ-2026/07 дугаар тогтоолоор Бага хурлыг 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр хуралдуулахаар зарлаж, мөн өдрийн намын Бага хуралд нийт 50 гишүүн оролцохоос 39 гишүүн оролцсон, эдгээр гишүүдийн нэрсийг Улсын дээд шүүхэд хадгалагдаж буй Тусгаар тогтнол, Эв нэгдлийн намын хувийн хэрэгт байгаа 2016 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит бус III Их хурлын 01/003 дугаар тогтоолын хавсралтаар баталсан 50 гишүүний нэрстэй тулгахад таарсан тул хуралд эрх бүхий этгээдүүд оролцсон нь дүрмийн 21.5-д заасан шаардлагыг хангасан байна.

Улмаар Бага хурлын 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн БХ-2026/02 дугаар тогтоолоор намын ээлжит бус V Их хурлыг 2026 оны 03 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулахаар товлон зарлаж, төлөөлөгчдийн тоог 120 байхаар тогтоосон, Бага хурлаас байгуулагдсан ажлын хэсэг нь эдгээр төлөөлөгчдөд ээлжит бус V Их хурлын товыг утсаар мэдэгдсэн, улмаар тухайн хуралд нийт 120 төлөөлөгчийн гуравны хоёроос дээш 90 төлөөлөгч оролцсон болох нь ирцийн бүртгэл, утсаар ярьсан бүртгэл, намын гишүүний үнэмлэхийн хуулбар, фото зураг, дүрс бичлэг болон бусад баримтаар тогтоогдож байгаа нь зөрчилгүй байна.

Хоёр.Намын шинэчилсэн дүрмийг баталсан талаар:

2.1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гээд 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж;

Тусгаар тогтнол, Эв нэгдлийн намын дүрэм (2017 он)-ийн 1.5-д “Нам үйл ажиллагаандаа хуульд заасан нийтлэг зарчмаас гадна дараах зарчмуудыг баримтлан ажиллана”, 1.5.4-т “нам нь аливаа асуудлыг чөлөөтэй хэлэлцэн цөөнхийн

саналд хүндэтгэлтэй хандаж, олонх нь дэмжсэн шийдвэрийг нийтээрээ дагаж биелүүлэх”, 17.4-т “Намын Их хурал намын бодлогын ямар ч асуудлыг хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ”, 17.4.1-д “Намын дүрэм, хичээн эрмэлзэх зүйл (мөрийн хөтөлбөр), ... тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж тус тус заажээ.

Өмнө нь, Тусгаар тогтнол, Эв нэгдлийн намын ээлжит IV Их хурлын 2025 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 0001 дүгээр тогтоолоор намын шинэчилсэн мөрийн хөтөлбөр, дүрмийг баталж, 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр бүртгүүлэхээр өргөдөл ирүүлснийг Улсын дээд шүүхийн 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 02/143 дугаар албан бичгээр “хурлын процесс болон дүрмийн зарим заалт нь хуульд нийцээгүй” гэж 5 үндэслэл бүхий 24 алдаа зөрчлийн талаар дурдаж буцаасан байна.

Уг албан бичгийг үндэслэн тус намын ээлжит бус V Их хурал 2026 оны 03 дугаар сарын 15-ны өдөр дахин хуралдаж, дээрх алдаа зөрчлийг арилган намын дүрмийг шинэчлэх асуудлыг хэлэлцэж, дүрмийн бүлэг тус бүрээр нь хуралд оролцсон 90 төлөөлөгчийн 80-100 хувийн саналаар дэмжин баталсан нь Тооллогын комиссын санал хураалтын нэгтгэл, ээлжит бус V Их хурлын “Намын шинэчилсэн дүрэм, мөрийн хөтөлбөрийг батлах тухай” ИХ-2026/02 дугаар тогтоол, хуралдааны тэмдэглэл, дүрс бичлэг зэрэг баримтаар тогтоогдож байна.

2.2.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэж;

Тусгаар тогтнол, Эв нэгдлийн намын дүрэм (2017 он)-ийн 20.3.13-т “намын Их хурлын чөлөө цагт дүрэм, мөрийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах асуудлыг Бага хурлын хуралдаанаар шийдвэрлэж болох ба ийнхүү шийдвэрлэсэн тохиолдолд оролцсон гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ ...” гэж тус тус заасан.

Өргөдөл шалгах ажиллагааны явцад тухайн шинэчлэн баталсан дүрмийн зарим заалт тодорхой бус байсан тул сонсох ажиллагаагаар тодруулсан ба тус намын Бага хурал 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр дахин хуралдаж, БХ-2026/04 дүгээр тогтоолоор шинэчилсэн дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт оруулж, холбогдох баримтын хамт ирүүлжээ.

Тухайн намын Бага хурал хуралдсан процессыг шалгахад, Удирдах зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдааны УЗ-2026/09 дүгээр тогтоолын дагуу 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Бага хурал хуралдаж, 50 гишүүн оролцохоос 35 гишүүн оролцсон, олонхын саналаар намын дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэсэн байх тул ямар нэгэн зөрчилгүй байна.

Тусгаар тогтнол, Эв нэгдлийн намын 2026 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит бус V Их хурлын ИХ-2026/02 дугаар тогтоолоор баталсан намын шинэчилсэн дүрэм нь 11 бүлэг, 31 зүйл, 149 хэсэг, 139 заалттай байсан, үүнээс 9 хэсэг, 20 заалтыг шинээр нэмж, 42 хэсэг, 21 заалтыг өөрчлөн найруулж, 7 хэсэг, 5 заалтыг хасаж, нийт 104 буюу дүрмийн 31.5 хувьд нь Бага хурлын 2026 оны 04 дүгээр сарын 09-ний

өдрийн БХ-2026/04 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Улс төрийн намын тухай хуулийн 17.4-т заасантай нийцсэн байна.

Гурав.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Намын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог энэ хуульд заасны дагуу намын дүрмээр зохицуулна”, 15.2-т “Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана” гээд 15.2.1-15.2.10-т намын дүрэмд тавигдах шаардлагыг тодорхойлжээ. Тодруулбал,

3.1.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-т “намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллага болон бусад байгууллага, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, хуралдуулах, шийдвэр гаргах журам” гэж заасан, намын дүрмийн 16.1-д “Тусгаар тогтнол, эв нэгдлийн намд удирдах дээд байгууллага нь намын Их хурал, төлөөллийн төв байгууллага нь намын Бага хурал ... байна”, 17.1-д “Ээлжит Их хурлыг дөрвөн жилд нэг удаа хуралдуулна”, 20.5-д “Намын Их хурал хуралдах тов, төлөөлөгчдийн тоо, тэдгээрийг сонгох журам, түүнчлэн Их хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Бага хурал тогтооно”, 20.2-т “Намын Их хурлаас намын Бага хурлыг 50 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр дараагийн Их хурал хүртэлх хугацаагаар байгуулна”, 20.8-д “Намын дүрэмд заасны дагуу намын бага хурал нь намын гүйцэтгэх төв байгууллага буюу Удирдах зөвлөлийг 4 жилээс илүүгүй хугацаагаар сонгоно. Удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байна”, 25.1-д “Тусгаар тогтнол, эв нэгдлийн намд гүйцэтгэх төв байгууллага нь Тусгаар тогтнол, эв нэгдлийн намын Удирдах зөвлөл байна. Удирдах зөвлөл нь намын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, намын бодлогын хэрэгжилтийг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 27.3-т “Намын Хяналтын Ерөнхий Хороог намын Их хурлаас 7-11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 4 жилийн хугацаатай сонгоно” гэж эдгээр байгууллагыг хуралдуулах, хурлын тов тогтоох, зар мэдэгдэх, хурал хүчин төгөлдөр болох нөхцөл, шийдвэр гаргах, санал хураалтын журам, мөн тус хурлын бүрэлдэхүүнд нэр дэвших, сонгох, сонгогдох болон бүрэлдэхүүнийг чөлөөлөх, огцруулах үндэслэл журмын талаар тус тус зохицуулжээ.

3.2.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан “намын гишүүнээр элсэх, намын гишүүнээс түдгэлзэх, намын гишүүний эрх, үүрэг, намын гишүүнээс хасах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл”-ийг намын дүрмийн дүрмийн 3 дугаар зүйлд намд гишүүнээр элсэх, 4 дүгээр зүйлд намын гишүүний эрх, үүрэг, 5 дугаар зүйлд намын гишүүнд сахилгын шийтгэл оногдуулах, гишүүнээс түдгэлзэх, хасах, 6 дугаар зүйлд намын гишүүнээс гарах зэрэг зохицуулалтыг заасан байна.

3.3.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д заасан “намын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, түүний бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ”-г намын дүрмийн 24.2-т “Намын даргыг намын Их хурлаас 4 жилийн хугацаатай сонгоно. Намын даргыг дараалан 2-оос илүүгүй удаа сонгож болно”, 24.3-т “намын даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэл”, 24.4-т “намын даргыг үүрэгт ажлаас нь огцруулах үндэслэл”, 24.6-д “Намын даргын эрх”, 24.7-д “Намын даргын үүрэг” гэж намын даргад нэр дэвших, сонгох, чөлөөлөх, огцруулах талаар ерөнхийлөн зохицуулсан.

3.4.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.9-д заасан “намын хөрөнгө, орлогыг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг дүрмийн 26.2-т “Намын хөрөнгөд дараах

зүйлс хамаарна” гэж, гишүүний татвар, гишүүн, дэмжигч хуулийн этгээдээс хуульд нийцүүлэн өгсөн хандив, Улс төрийн намын тухай хуульд заасан төрөөс олгох санхүүгийн дэмжлэг, намын бэлгэдэл бүхий, бэлэг дурсгалын зүйлс, намын өмчлөлд байгаа эд зүйлсийг борлуулалтын орлого, намын хэвлэл, мэдээлэл сурталчилгааны орлого, өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг худалдах буюу түрээслүүлж ашиглуулснаас олсон орлого, намын мөнгөн хөрөнгийг банканд хадгалуулсны хүү зэргээс бүрдэхээр зохицуулсан байна. Мөн дүрмийн 26.3.1-26.3.3 дахь заалтуудад төрөөс олгох санхүүгийн дэмжлэгийн талаар тусгажээ.

Дээрх байдлаас үзэхэд, Тусгаар тогтнол, Эв нэгдлийн намын 2026 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит бус V Их хурлын ИХ-2026/02 дугаар тогтоолоор баталсан намын шинэчилсэн дүрэмд Бага хурлын 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн БХ-2026/04 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагад нийцэж байх тул шинэчилсэн дүрмийг бүртгэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.5 дахь хэсэгт заасныг баримтлан Тусгаар тогтнол, Эв нэгдлийн нам (ТТЭНН)-ын шинэчилсэн дүрмийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ